



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/200

Улаанбаатар хот

Газар эзэмшүүлэх төсөл сонгон
шалгаруулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”, Засгийн Газрын 2025 оны 120 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2024 оны А/77 дугаар захирамж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны А/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн”-д дэмжлэг үзүүлэх зорилгоор дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1 нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс зарлаж, төслийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 17 цаг хүртэл хүлээн авч, танхимаар зохион байгуулахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

1225010658

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 12 дугаар сарын 26 ны өдрийн
12 дугаар захирамжийн хавсралт



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ЭЗЭМШҮҮЛЭХ ХУГАЦАА

№	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ (м2)	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх хугацаа
1	Багахангай дүүргийн 2 дугаар хороо Мэргэний зүүн хойно	Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	49735	4285989	15 жил

